

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭРХЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНД
 ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА.**

НЭГ. Эрчим хүчийн барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд

Суурь нөхцөл, шаардлага:

- Зураг төслийн ажил эрхлэхээр тусгай зөвшөөрөл авах хуулийн этгээдийн захирал нь мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан барилгын төрөл, мэргэжлийн чиглэлээр мэргэшлийн зэрэгтэй байх,
- Зургийн ерөнхий инженер, архитектор, бүтээцийн инженер болон холбогдох ажилбарыг гүйцэтгэх ИТА-ны бүрэлдэхүүн, компьютерийн тоног төхөөрөмж, программ хангамж, баталгаажсан хэмжилтийн багаж хэрэгсэл, холбогдох норм. дүрмийн сантай байх

Ажлын төрөл	Байвал зохих ИТА	ИТА-ны ажлын туршлага	Байвалзохих БНБД-үүд, стандартууд	Аж ахуйн нэгжийн Өөрийн зэмшлийн тоног төхөөрөмж, программ хангамж
1	2	3	4	5
1.1.1 Дотор гэрэлтүүтэг. Цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүний холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл)	Цахилгааны инженер-2, Зургийн техникч	инженер: Зураг төслийн байгууллагад мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан байна. (гадна болон дотор инженерийн шугам сүлжээний ажлын дадлага, туршлагатай байх), аль нэг нь мэргэжлийн зэрэгтэй байх	Цогцолбор 43	Компьютер, тоног төхөөрөмж, тооцооны программ хангамж

1.1.2 КИП, автоматик	Автоматикийн инженер -1 "Зургийн техникч	инженер: Зураг төслийн байгууллагад мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан байх.мэргэжлийн зэрэгтэй байх	Цогцолбор 43	Компьютер, тоног төхөөрөмж, тооцооны программ хангамж
1.1.3 25 МПа-аас дээш даралтай дулааны шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи	Дулааны инженер - 2 Зургийн техникч	Инженер: Аль нэг нь зураг төслийн байгууллагад мэргэжлээр 10 ба түүнээс дээш жил ажилласан, Зөвлөх зэрэгтэй байх	Цогцолбор 20 Цогцолбор41	Компьютер, тоног төхөөрөмж, тооцооны программ хангамж нивелир, теодолит гэх мэтийн геодезийн хэмжилтийн[багаж
1.1.4 Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи /35 кВ хүртэл/	Цахилгааны инженер - 2 Зургийн техникч	Инженер: Аль нэг нь зураг төслийн байгууллагад мэргэжлээр 10 ба түүнээс дээш жил ажилласан, Зөвлөх зэрэгтэй байх	Цоцолбор 23 Цогцолбор 43	Компьютер, тоног төхөөрөмж, тооцооны программ хангамж
1.1.5 Цахилгаан дамжуула ^а гал шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи /220 кВ хүртэл/	Цахилгааны инженер - 2 Реле хамгаалалтын инженер -1, Өндөр үелзлэлийн холбооны инженер - 1, Барилгын инженер - 1, Зургийн техникч	Цахилгааны инженер: Аль нэг нь зураг төслийн байгууллагад мэргэжлээр 10 ба түүнээс дээш жил ажилласан, зөвлөх зэрэгтэй байх Бусад инженер : Аль нэг нь мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан , мэргэжлийн зэрэгтэй байх	Цогцолбор 23 Цогцолбор 43	Компьютер, тоног төхөөрөмж, тооцооны программ хангамж
1.1.6 Эрчим хүчний байгууламжийн технологийн зураг төсөл	Технологи инженер -2 Зургийн техникч	Инженер : Аль нэг нь тухайн технологийн чиглэлээр 10 ба түүнээс дээш жил ажилласан, Зөвлөх зэрэгтэй байх	Цогцолбор 21 Цогцолбор 23 Цогцолбор 43	Компьютер, тоног төхөөрөмж, тооцооны программ хангамж

Хоёр. Эрчим хүчний эх үүсвэр, цахилгаан дамжуулах шугам, дэд станц, зуух, даралтат сав, шугам хоолой, дулаан хуваарилах байгууламж, ЦТП-ын засвар, угсралтын үйлчилгээ эрхлэх ажлын хүрээнд

Ажилбар	Байвал зохих ИТА	ИТА-н ажлын туршлага	Мэргэжилтэй ажилчид	Ажилчдад тавигдах шалгуур	Байвал зохих БНБД	Аж ахуйн нэгжийн өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж
1	2	3	4	5	6	7
2.1. Эрчим хүчний эх үүсвэр, цахилгаан дамжуулах шугам, дэд станц						
1. Ажил, үйлчилгээнд тавих нөхцөл, шаардлага: Ерөнхий инженер, сантехникийн инженер-1, дулааны инженер-1, цахилгааны инженер-1, чанарын инженер-1, хөдөлмөр хамгааллын инженер-1, барилгын техникч-1, цахилгаан ба хийн гагнуурчин, сантехникийн ба дулааны слесарьч, цахилгаанчин, уур, ус дулаан тусгаарлалтын ажилчин, компрессор, трансформатор, цахилгаан ба хийн гагнуурын аппарат, труба матагч, тайрагч, резьба татагч, даралт шалгагч, цахилгааны төрөл бүрийн шалгагч, кабель шалгагч зэрэг тоног төхөөрөмжтэй, тухайн ажлыг гүйцэтгэхэд ашиглах норм, дүрмийн баримт бичгийн иж бүрдэлтэй байна.						
2.1.1.						
2.1.2. Цахилгаан эрчим хүч дамжуулах гол /магистралы/ шугам /110 кВ хүртэл/ угсралт	Цахилгаан сүлжээ, станцын инженер 3-аас доошгүй, Реле хамгаалалтын инженер-1 Дэд станцын инженер-1 Барилгын инженер-1 Цахилгааны техникч-2	Мэргэжлээрээ 5 ба түүнээс доошгүй жил ажилласан байх, Энэ төрлийн 3-аас доошгүй шугамын барилга хариуцан гүйцэтгэсэн байх, аль нэг инженер нь зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх	Цахилгаанчин, Гагнуурчин. Кабельчин, өндөр хүчдэлийн шугамын засварчин, холбооны засварчин, арматурчин зэрэг мэргэжилтэй 15-аас доошгүй	Ажилчдын 40 хувь нь 5-аас доошгүй жил ажилласан, цахилгаанчин нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан мэргэжлийн зэрэгтэй байх	1. БНБД 3.0.05-85 2. БНБД 3.05.06-90 3. БНБД 3.05.08-89 4. БНБД 3.05.08-89 5. БНБД 3.05.06-85 6. БД 43-101-03. Стандарт. 1. MNS 3953: 1986 2. MNS 4187: 1993 3. MNS 2285: 1995? 4. MNS 2691: 1985? 5. MNS 3856: 1985	-Өргөх буулгах машин механизм -гагнуурын трансформатор -Дөрөө, бүс холбогдох тоног төхөөрөмж -Хүчдэл гүйдэл хэмжигч хэмжүүрийн багаж, - ампер клеш, -Теодолит, нивелир - Өргүүр -Агаарын шугамын утас хөвөгч машин. гэх мэт бусад тоног

	Өндөр үелзлэлийн холбооны инженер-1 Хянах хэмжүүр, автоматикийн инженер-1		ажилчидтай байх .		6. MNS 3857: 1985? 7. MNS 3757-16: 84? 8. MNS 3757-16: 84? 9. MNS 4186:1993 10. MNS 3236:89 11. MNS 4232:94 12. MNS 3386:82 13. MNS 4699:99 гэх мэт бусад холбогдох баримт бичгүүд хамрагдана.	төхөөрөмжүүд хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх
2.1.3. Цахилгаан эрчим хүч дамжуулах гол /магистраль/ шугам /110 кВ-с дээш / угсралт	Цахилгаан сүлжээ, станцын инженер 3-аас доошгүй, Реле хамгаалалтын инженер-1 Дэд станцын инженер-1 Барилгын инженер-1 Цахилгааны техникч-2 Өндөр үелзлэлийн	Мэргэжлээрээ 5 ба түүнээс доошгүй жил ажилласан. Энэ төрлийн 3-аас доошгүй шугамын барилга хариуцан бариулсан байх, аль нэг инженер нь зөвлөх эсвэл мэргэшсэн зэрэгтэй байх	Цахилгаанчин, Гагнуурчин. Кабельчин, өндөр хүчдэлийн шугамын засварчин, холбооны засварчин, арматурчин бусад мэргэжилтэй 15-аас доошгүй ажилчидтай байх .	Ажилчдын 40 хувь нь 5-аас доошгүй, жил ажилласан байх, цахилгаанчин нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан мэргэжлийн зэрэгтэй байх	1.БНБД 3.0.05-85 2.БНБД3.05.06-90 3.БНБД3.05.08-89 4.БНБД3.05.08-89 5.БНБД3.05.06-85 6.БД43-101-03. Стандарт. 1.MNS 3953: 1986 2.MNS 4187: 1993 3.MNS 2285:1995 4.MNS 2691: 1985 5.MNS 3856: 1985 6. MNS 3857: 1985 7. MNS 3757-16: 84 8. MNS 3757-16: 84	-Өргөх буулгах машин механизм -Гагнуурын трансформатор -Дөрөө, бүс холбогдох тоног төхөөрөмж -Хүчдэл гүйдэл хэмжигч хэмжүүрийн багаж, - ампер клеш, -Теодолит,нивелир -Өргүүр -Төрөл бүрийн вибратор -Агаарын шугамын утас хөвөгч машин. гэх мэт бусад тоног

	холбооны инженер-1 Хянах хэмжүүр автомаикийн инженер-1				9. MNS 4186:1993 10. MNS 3236:89 11. MNS 4232:94 12. MNS 3386:82 13. MNS 4699:99 гэх мэт бусад холбогдох баримт бичгүүд хамаргна.	төхөөрөмжүүд хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх
--	---	--	--	--	--	---

3.1. Зуух, даралтат сав, шугам хоолой, дулаан хуваарилах байгууламж, даралтанд ажилладаг тоноглолын засвар, угсралтын ажил, үйлчилгээнд тавигдах нөхцөл, шаадлага:

Ерөнхий инженер, дулааны инженер-1, механик инженер-1, сантехникийн инженер-1, барилгын техник-1, цахилгаан ба хийн гагнуурчин, сантехникч, слесарь зэрэг мэргэжлийн ажилчидтай, гагнуурын аппарат, компрессор, даралт шалгагч, гагнуур шалгагч, металл тайрагч, хэмжүүрийн багаж, монометр зэрэг тоног төхөөрөмжтэй, холбогдох норм, дүрмийн баримт бичгийн зохих бүрдэлтэй байна

Ажилбар	Байвал зохих ИТА	ИТА-н ажлын туршлага	Мэргэжилтэй ажилчид	Ажилчдад тавигдах шалгуур	Байвал зохих БНБД	Аж ахуйн нэгжийн өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж
3.1.1. Даралтат сав, шугам хоолойн угсралтын ажил	Дулааны инженер-1, металлын инженер-1 сантехникийн инженер-1, цахилгааны инженер-1, барилгын инженер-1, КиП автомаикийн инженер-1, хөдөлмөр хамгааллын инженер-1,	Мэргэжлээрээ 5 ба түүнээс доошгүй жил ажилласан байх, зонхилох инженер нь мэргэжлийн зэрэгтэй байх	Цахилгаанч ин, тоног төхөөрөмжийн засварчин, гагнуурчин зэрэг мэргэжлийн 15-аас доошгүй ажилчидтай байх	Ажилчдын 40 хувь нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн зэрэг бүхий үнэмлэх, сертификатай байх	Цогцолбор 40, 41	Гар таль, кран, насос, гагнуурын аппарат, компрессор, хэмжүүр, хэмжин шалгах багаж, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх

3.1.2. Өндөр даралтын зуухны угсралтын ажил	Зуухны инженер-1, дулааны инженер-1, металлын инженер-1 КиП автоматикийн инженер-1, Хөдөлмөр хамгааллын инженер-1	Мэргэжлээрээ 5 ба түүнээс доошгүй жил ажилласан байх, энэ төрлийн 3-аас доошгүй тогооны угсралт хийсэн байх, зонхилох инженер нь мэргэжлийн зэрэгтэй байх	Тогоо угсрагч, сантехник-слесарь, цахилгаанч ин зэрэг 10-аас доошгүй мэргэжлийн ажилчидтай байх	Ажилчдын 40 хувь нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн зэрэг бүхий үнэмлэх, сертификатай байх	Цогцолбор 41	Гар таль, кран, насос, гагнуурын аппарат, компрессор, хэмжүүр, хэмжин шалгалтын багаж, индикатор, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх
3.1.3. Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт	Дулааны инженер-1, Сантехникийн инженер-1, Дулааны техникч-1, Сантехникч-1, Геодезийн инженер-1	Мэргэжлээрээ 5 ба түүнээс доошгүй жил ажилласан, энэ төрлийн угсралтын 3-аас доошгүй объектын ажил хариуцан бариулсан байх, Дулааны инженер, Сантехникийн аль нэг нь мэргэжлийн зэрэгтэй байх	Сантехникч, засварчин бусад мэргэжлийн 10-аас доошгүй ажилчидтай байх	Ажилчдын 40 хувь нь мэргэжлийн ажилд 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн үнэмлэхтэй байх	1. БНБД 2.01.03-92 2. БНБД 2.01.03-92/03 3. БД 23-101-03 4. БД 23-102-03 5. MNS 4990-2000 6. БНБД 3.01.03-88 7. БНБД 41-01-02 8. СНИП 2.04.07-86 9. БНБД 3.05.03-95 10. БНБД 41.03-99 11. БНБД 3.05.05-89 12. СНИП IIIГ10.4-67 гэх мэт бусад холбогдох баримт бичгүүд хамрагдана.	Суваг ухагч, укладчик, экскаватор, бульдозор, нягтруулагч, гагнуурын аппарат, трансформатор, компрессор, нивелир, теодолит, шалгах аппарат, багажнууд хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх

4. Эрчим хүчний байгууламжид туршилт тохируулга хийх, бусад дагалдах ажил үйлчилгээ эрхлэх ажлын хүрээнд

4. Ажил, үйлчилгээнд тавигдах нөхцөл, шаардлага:

Ерөнхий инженер, Эдийн засагч, дулааны инженер, цахилгааны инженер, реле хамгаалалт, тавил тооцооны инженер, хянах хэмжүүр, автоматикийн инженер, механик инженер, сантехникийн инженер, барилгын техник, холбогдох норм, дүрмийн баримт бичгийн зохих бүрдэлтэй байна.

4.1.1. Туршилт тохируулгын ажил	Цахилгааны инженер дулааны инженер, мэргэжилтнүү уур ус, түлшний шинжилгээний лабораторин инженерүүд зохион бүтээгч	Мэргэжлээрээ 5-ба түүнээс дээш жил ажилласан байх, мэргэшлийн зэрэгтэй байна.			Шаардагдах норм, дүрмийн баримт бичгийн зохих бүрдэлтэй байна	Компьютер, тоног төхөөрөмж, (оруулах ба гаргах төхөөрөмжүүд) Холбогдох программ хангамж Уур, ус, түлш, тосны шинжилгээний химийн лаборатори, Хянах хэмжих зөөврийн багаж хэрэгсэл
---------------------------------	---	---	--	--	---	---

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАЙГУУЛАМЖИЙН ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ, ЭХ ҮҮСВЭР, ШУГАМ СҮЛЖЭЭ БАРЬЖ БАЙГУУЛАХ,
ЗУУХ ДАРАЛТАТ САВ, ШУГАМ ХООЛОЙН УГСРАЛТ, ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АСУУДЛААР УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ
ГАРГАХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРМЫН ДӨРӨВДҮГЭЭР ХАВСРАЛТ

Ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд дараахь
мэдээлэл агуулагдсан байна.

Соёмбо

Монгол Улсын
Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны
төв байгууллага

Тусгай зөвшөөрөл

Дугаар

Аж ахуйн нэгж, байгууллагын харъялагдах хот, аймаг, дүүрэг
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаар

Үйлчлэх хүрээ

Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа

Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын

тамга

сайдын гарын үсэг

он сар өдөр

Улаанбаатар хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАЙГУУЛАМЖИЙН ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ, ЭХ ҮҮСВЭР, ШУГАМ СҮЛЖЭЭ БАРЬЖ БАЙГУУЛАХ,
ЗУУХ ДАРАЛТАТ САВ, ШУГАМ ХООЛОЙН УГСРАЛТ, ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АСУУДЛААР УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ
ГАРГАХ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРМЫН ТАВДУГААР ХАВСРАЛТ

Батлав. Эрчим хүчний асуудал
эрхэлсэн Төрийн захиргааны
байгууллагын дарга

Батлав. “.....” ХХК-ийн
захирал

..... / / / /

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГЧ,
ТҮҮНИЙГ ЭЗЭМШИГЧИЙН ХООРОНД
БАЙГУУЛСАН ГЭРЭЭ**

20 оны .. дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1. Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 7.1, 15.8.2, 15.8.5 дугаар зүйлд заасны дагуу олгосон тусгай зөвшөөрлийн хавсралт энэхүү гэрээг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид зөвшөөрөл олгогч гэх/ “.....” ХХК/цаашид зөвшөөрөл эзэмшигч гэх/-ын хооронд 20.....оны ... дугаар сарын ...-ны өдрөөс тооцож байгуулав.

2. Энэхүү гэрээ нь хоёр талын гарын үсэг зурж баталгаажуулсанаас жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд талууд гэрээнд заасан үүргийн биелэлтийг тооцож гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө хамтран дүгнэнэ.

3. Олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, гэрээнд заасан үүрэг хариуцлага хүлээхдээ хоёр тал Монгол улсын хууль, тогтоомж, түүний дотор “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хууль, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах” хууль болон “Эрчим хүчний байгууламжийн зураг, төсөл хийх, ТЭЗҮ боловсруулах, эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, эрчим хүчний тоног төхөөрөмж байгууламж, зуух, даралтат сав, шугам хоолойн засварын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”, энэхүү гэрээ зэрэг бусад нийтлэг дүрэм журмыг мөрдөнө.

Хоёр. Гэрээнд оролцогч талуудын нэр, хаяг

2.1. Зөвшөөрөл олгогч тал:

Улаанбаатар хот: Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны
байгууллага

2.2. Зөвшөөрөл эзэмшигч тал:

Холбооны салбар:....- ш/х-

Гудамжны нэр: ...
Утас: ...
Факс: ...
И-мэйл: ...@...

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Үйлчилгээний хүрээ нь:

Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байна.

3.2. Дор дурдсан ажил үйлчилгээний төрлийг эрхэлнэ.

А. кВ-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга дагалдах ажил үйлчилгээ

Б. МВТ-ын эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, түүний туршилт тохируулга дагалдах ажил үйлчилгээ

В. кгх/см² даралттай зуухны засвар, угсралт, түүний туршилт тохируулга дагалдах ажил үйлчилгээ....гм

3.3. Тусгай зөвшөөрөлд заасан тухайн төрлийн ажил үйлчилгээний чиглэлээр сонгон шалгаруулалтад оролцох.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

4.1. Зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхтэй холбогдсон норм дүрэм, стандарт, техникийн нөхцөл, технологи, зураг төсөл норматив техникийн бусад баримт бичгийг чанд мөрдөн, чанарын шаардлагыг бүрэн хангаж, гүйцэтгэсэн ажлын чанарын баталгааг хариуцна.

4.2. Техникийн магадлал, туршилт хийлгэж баталгаажуулах шаардлагатай, өөрийн эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд хийгдэж буй ажлуудад техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм журамд заагдсаны дагуу зохих хугацаанд нь туршилт, магадлалт баталгаажуулалт хийлгэж, улсын мэргэжлийн байгууллагын байнгын хяналтанд ажиллана.

4.3. Үйлдвэрлэлийн осол аваариас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж улсын хяналтад хамаарах объектод гарсан осол аварийн талаар Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдэгдэн, осол аварийн тайлан мэдээг хагас бүтэн жилээр гаргаж, мэдээлэл өгч байна.

4.4. Өөрсдийн аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй ИТА, ажилчдын /монтёр гагнуурчин, засварчин, кранчин, машинч гэх мэт бусад/ мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургалтыг зохион байгуулж, тэднийг жил бүр шалгалт, аттестатчилалд оруулж ажиллана.

4.5. Өөрийн эрхэлж буй ажил үйлчилгээний талаар хэрэглэгчийн зүгээс тавьсан санал гомдлыг шийдвэрлэн барагдуулж байх бөгөөд энэ талаар тусгай зөвшөөрөл олгогчид жил бүр мэдээлж байна.

4.6. Эрхэлж буй ажил үйлчилгээний хүрээнд зах зээлийн шударга өрсөлдөөнд саад учруулах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4.7. Шинэ нэр төрлийн ажил үйлчилгээ эрхлэх бол энэ тухай хүсэлтээ зөвшөөрөл олгогчид гаргаж, шийдвэрлүүлнэ.

4.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах холбогдох зардлыг /Зөвшөөрлийн гэрчилгээний үнэ, норм, дүрэм, гарын авлага, бичиг хэргийн зардал г.м/ зөвшөөрөл олгогчид өгнө.

Тав. Тусгай зөвшөөрөл олгогчийн үүрэг

5.1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон баримт бичгийг хянах, газар дээр нь очиж танилцах, үнэлэлт дүгнэлт гаргах, зөвшөөрөл бичиж олгох, гэрээ байгуулах, хүчинтэй хугацааг тодорхойлох, олгосон тусгай зөвшөөрөл, байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг шалгах зэрэг ажлыг хэрэгжүүлнэ.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын ажил үйлчилгээний чанар норм дүрэм, стандарт техникийн нөхцөл, технологийн мөрдөлтөд хяналт тавина.

5.3. Тусгай зөвшөөрөлд заасан ажил үйлчилгээ эрхлэх болон энэхүү гэрээний гуравдугаар зүйлд заасан үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу баталгаажуулж, эрх ашгийг нь хамгаалж ажиллана.

5.4. Зөвшөөрөл эзэмшигч үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад гарсан томоохон аваарь хүний амь үрэгдүүлсэн, хүнд бүлэг ослыг судлахад оролцож, акт дүгнэлт гарган тэдгээрийг дахин гаргуулахгүй байх арга хэмжээ авч ажиллана.

5.5. Зөвшөөрөл эзэмшигчийн эрхэлж буй ажил үйлчилгээний талаар гарсан хүсэлт санал гомдлыг тухай бүр нь хүлээн авч хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэнэ.

5.6. Хоёр тал гэрээг хамтран дүгнээд зөвшөөрөл эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэнд тооцсон нөхцөлд анх олгосон тусгай зөвшөөрлийн хугацааг хүчинтэйд тооцох ба хугацаа дууссан бол уг тусгай зөвшөөрлийг журамд заасан хугацаагаар шинээр бичиж олгоно.

Зургаа. Хариуцлага, төлбөр

6.1. Хоёр тал тухайн гэрээ болон тусгай зөвшөөрөлд заасан үүргээ биелүүлээгүй бол хууль тогтоомжийн дагуу торгууль хүлээх болон зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үйлчилгээний төлбөрийг тодорхой хэмжээгээр хорогдуулах зэрэг хариуцлагыг харилцан хүлээнэ.

6.2. Зөвшөөрөл эзэмшигч нь “Эрчим хүчний байгууламжийн зураг, төсөл хийх, ТЭЗҮ боловсруулах, эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламж, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт засварын ажил эрхлэх зөвшөөрөл олгох журам” ба энэхүү гэрээнд заасан ажил үйлчилгээний төлбөрт ... ₮-ийг Төрийн Сан Банкин дахь 900030023 тоот дансанд 20 ... оны ... сарын ... -ны өдөр багтаан шилжүүлнэ. /₮-ийг шилжүүлнэ/

6.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай аливаа саналыг талууд албан бичгээр харилцан солилцож, тавьж шийдвэрлүүлнэ.

6.4. Жил бүр гэрээгээ дүгнэхдээ нормчлолын сангийн тооцоог нийлсэн байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Тусгай зөвшөөрөл олгогчийг төлөөлж:	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:
ТЗ-ийн комиссийн дарга	Ерөнхий ня-бо, менежер, инженер
..... / /
Харилцах утас:	Харилцах утас: